



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 432

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 398,608,00.00 (гурван зуун ерэн найман сая зургаан зуун найман) төгрөгийн балансын үнэ бүхий нэгдүгээр хавсралтад заасан хөрөнгийг Хими, хими технологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 160,000,000.00 (нэг зуун жаран сая) төгрөгийн балансын үнэ, 160,000,000.00 (нэг зуун жаран сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хоёрдугаар хавсралтад заасан хөрөнгийг “Дархан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Хими, химийн технологийн хүрээлэнгийн захирал Л.Жаргалсайхан, “Дархан-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Баясгалан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

000089/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 10 дугаар сарын 29 өдрийн
432 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн эгтгээд
1	Автомат дээж өгөх систем	2014	ш	1	5,807,000.00	5,807,000.00	Хими, химийн технологийн хүрээлэн
2	Автомат ууршуулагч систем	2014	ш	1	8,898,000.00	8,898,000.00	
3	Азатын урсгалаар өтгөрүүлэгч багаж	2014	ш	1	10,907,000.00	10,907,000.00	
4	Аналитик жин	2014	ш	1	4,065,000.00	4,065,000.00	
5	Колонк	2014	ш	1	1,435,000.00	1,435,000.00	
6	Соклетын хандалт явуулах багаж	2014	ш	1	3,689,000.00	3,689,000.00	
7	Тог баригч	2014	ш	1	7,776,000.00	7,776,000.00	
8	Хроматографын багаж	2014	ш	1	355,190,000.00	355,190,000.00	
9	Хэт авианы цэвэрлэгч	2014	ш	1	841,000.00	841,000.00	
НИЙТ ДҮН				9	398,608,000.00	398,608,000.00	
					(гурван зуун ерэн найман сая зургаан зуун найман мянга)		

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газр
2019 оны ... 00 дугаар сарын 29 өдрийн
... 432 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХӨВСГӨЛИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Машин механизмын марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Эксватор-140 CAT-mw24c мотор 10354548	1985/2000	80,000,000.00	80,000,000.00	80,000,000.00	0.00	"Дархан- Азза" ТӨХК
2	Автогрейдер CAT-130GML арал 5P39991	1973/2000	80,000,000.00	80,000,000.00	80,000,000.00	0.00	
НИЙТ ДҮН				160,000,000.00	160,000,000.00		
					(нэг зуун жаран сая)		